

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Бөөнцагаан-Орог нуурын сав газрын захиргааны 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БНА-2023/174/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Баянхонгор хот 2023 он	Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn Аудитын менежер: А.Цээням Утас: 99442140 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn Аудитор: Б.Нарангэрэл Утас: 99009293 Цахим хаяг: Narangerelb@audit.gov.mn Цахим хуудас: www.audit.mn
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	10
4. АУДИТЫН ТАЙЛАН	13
4.1 Ерөнхий зүйл.....	13
4.2 Материаллаг байдал	13
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	13
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	13
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	14
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	14
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	14
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	15
5.1 Төлбөрийн акт	15
5.2 Зөвлөмж.....	15
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	16

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584
Цахим шуудан: procurement.bayankhongor@audit.gov.mn

2023.02.15 № 2/18

танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Бөөнцагаан-Орог нуурын сав газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бөөнцагаан-Орог нуурын сав газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан.

Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилтын хүрээнд 31 арга хэмжээг

D- alban bichig 2022 A4 TOOT

005020153

хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 92.0 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан. Танилцахад материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Б.МӨНХБАТ

D- alban bichig 2022 A4 TOOT

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	28,284,238.00	17,711,989.00
33	АВЛАГА	0	5,000,000.00
33500	Бусад авлага	0	5,000,000.00
33510	Байгууллагаас авах авлага	0	5,000,000.00
34	УРЬДЧИЛГАА	8,000,000.00	0
34600	Урьдчилж гарсан зардал	8,000,000.00	0
35	БАРАА МАТЕРИАЛ	20,284,238.00	12,711,989.00
35100	Түүхий эд материал	9,212,330.00	5,586,380.00
35110	Тусгай зориулалттай материал	9,212,330.00	5,586,380.00
35400	Хангамжийн материал	11,071,908.00	7,125,609.00
35410	Бичиг хэргийн материал	828,000.00	0
35420	Аж ахуйн материал	4,584,499.00	3,318,000.00
35430	Сэлбэг хэрэгсэл	2,900,000.00	2,900,000.00
35440	Түлш, шатах тослох материал	2,124,409.00	907,609.00
35470	Бусад хангамжийн материал	635,000.00	0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	60,368,145.14	68,477,477.89
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	60,368,145.14	68,477,477.89
39200	Биет хөрөнгө	60,368,145.14	50,477,477.89
39203	Авто-тээврийн хэрэгсэл	76,495,500.00	76,495,500.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-32,287,899.96	-37,911,824.91
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	54,457,041.52	54,457,041.52
39206	Хуримтлагдсан элэгдэл	-41,793,375.03	-45,095,850.94
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	12,856,884.39	12,856,884.39
39208	Хуримтлагдсан элэгдэл	-9,360,005.78	-10,324,272.17
39300	Биет бус хөрөнгө	0	18,000,000.00
39301	Програм хангамж	770,000.00	770,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-770,000.00	-770,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	0	18,000,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	88,652,383.14	86,189,466.89
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	85,083.12	0
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	85,083.12	0
41300	Өглөг	85,083.12	0
41360	Бусад өглөг	85,083.12	0
41364	НДШ-ийн өглөг /ТӨҮГ/	85,083.12	0
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	88,567,300.02	86,189,466.89
51	Засгийн газрын хувь оролцоо	88,567,300.02	86,189,466.89
51200	Хуримтлагдсан үр дүн	88,567,300.02	86,189,466.89
51210	Өмнөх үеийн үр дүн	37,288,509.46	88,567,300.02
51220	Тайлант үеийн үр дүн	51,278,790.56	-2,377,833.13
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	88,652,383.14	86,189,466.89

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

		/төгрөгөөр/	
Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	248,201,265.52	206,265,500.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	44,637,465.52	193,200.00
120	Нийтлэг татварын бус орлого	44,637,465.52	193,200.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	44,161,275.52	0
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	476,190.00	193,200.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	203,563,800.00	206,072,300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	170,363,800.00	159,937,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	170,363,800.00	159,937,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	33,200,000.00	46,134,800.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	33,200,000.00	46,134,800.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	196,922,474.96	208,643,333.13
21	УРСГАЛ ЗАРДАЛ	196,922,474.96	208,643,333.13
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	180,661,153.72	174,497,334.13
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	111,431,927.00	98,457,516.00
210101	Үндсэн цалин	111,431,927.00	98,457,516.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	15,825,386.88	12,486,728.88
210201	Тэтгэврийн даатгал	11,240,626.48	8,517,420.44
210202	Тэтгэмжийн даатгал	1,146,190.90	1,012,060.55
210203	ҮОМШӨ-ний даатгал	916,952.48	809,645.61
210204	Ажилгүйдлийн даатгал	229,238.42	192,914.28
210205	Эрүүл мэндийн даатгал	2,292,378.60	1,954,688.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	8,820,000.00	8,820,000.00
210304	Байрны түрээс	8,820,000.00	8,820,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	9,371,616.00	13,151,062.00
210401	Бичиг хэрэг	1,344,900.00	1,566,400.00
210402	Тээвэр, шатахуун	4,425,779.00	4,590,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	826,839.00	1,133,113.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,093,200.00	1,170,750.00
210408	Бараа материал акталсны зардал	1,680,898.00	4,690,799.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	392,950.00	740,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	130,000.00	740,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	262,950.00	0
2107	Томилолт, зочны зардал	3,106,800.00	1,099,200.00
210702	Дотоод албан томилолт	3,106,800.00	1,099,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	24,379,909.00	29,522,360.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	23,705,317.00	28,760,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	200,000.00	240,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	79,500.00	79,500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	140,092.00	96,360.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	222,000.00	324,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7,332,564.84	10,220,467.25
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	0	329,800.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	7,332,564.84	9,890,667.25
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	16,261,321.24	34,145,999.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	16,261,321.24	34,145,999.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	14,927,021.24	33,945,999.00
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	1,334,300.00	200,000.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	51,278,790.56	-2,377,833.13
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	51,278,790.56	-2,377,833.13

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

		/төгрөгөөр/	
Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	203,563,800.00	206,072,300.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	203,563,800.00	206,072,300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	170,363,800.00	159,937,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	170,363,800.00	159,937,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	33,200,000.00	46,134,800.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	33,200,000.00	46,134,800.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	200,063,800.00	196,072,300.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	200,063,800.00	196,072,300.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	183,802,478.76	161,926,301.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	111,740,057.90	98,457,516.00
210101	Үндсэн цалин	84,460,949.90	78,410,774.00
210102	Нэмэгдэл	20,024,108.00	13,360,342.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	7,255,000.00	6,686,400.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	15,432,172.86	12,571,812.00
210201	Тэтгэврийн даатгал	10,847,412.46	8,602,503.56
210202	Тэтгэмжийн даатгал	1,146,190.90	1,012,060.55
210203	ҮОМШӨ-ний даатгал	916,952.48	809,645.61
210204	Ажилгүйдлийн даатгал	229,238.42	192,914.28
210205	Эрүүл мэндийн даатгал	2,292,378.60	1,954,688.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	8,820,000.00	7,385,200.00
210304	Байрны түрээс	8,820,000.00	7,385,200.00
2104	Хангамж, бараа материалын зардал	6,320,439.00	4,805,613.00
210401	Бичиг хэрэг	857,400.00	444,200.00
210402	Тээвэр, шатахуун	3,173,000.00	2,440,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,197,839.00	1,133,113.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,092,200.00	788,300.00
2105	Нормативт зардал	624,000.00	0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	624,000.00	0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	866,400.00	580,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	510,000.00	580,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	356,400.00	0
2107	Томилолт, зочны зардал	2,906,800.00	1,099,200.00
210702	Дотоод албан томилолт	2,906,800.00	1,099,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	37,092,609.00	36,697,160.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	36,390,017.00	35,934,800.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	200,000.00	240,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	79,500.00	79,500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	140,092.00	96,360.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	250,000.00	324,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0	329,800.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	0	329,800.00

Бөөнцагаан-Орог нуурын сав газрын захиргааны 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	203,563,800.00	206,072,300.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	16,261,321.24	34,145,999.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	16,261,321.24	34,145,999.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	14,927,021.24	33,945,999.00
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	1,334,300.00	200,000.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	3,500,000.00	10,000,000.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	3,500,000.00	10,000,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	3,500,000.00	10,000,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	3,500,000.00	10,000,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	3,500,000.00	10,000,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-3,500,000.00	-10,000,000.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		0.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		0.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0	37,288,509.46	37,288,509.46
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0	37,288,509.46	37,288,509.46
9	Тайлант үеийн үр дүн	0	51,278,790.56	51,278,790.56
10	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0	88,567,300.02	88,567,300.02
11	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0	88,567,300.02	88,567,300.02
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0	88,567,300.02	88,567,300.02
19	Тайлант үеийн үр дүн	0	-2,377,833.13	-2,377,833.13
20	2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	0	86,189,466.89	86,189,466.89

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	159,937,500.00	125,991,501.00	33,945,999.00	78.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	159,937,500.00	125,991,501.00	33,945,999.00	78.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	159,937,500.00	125,991,501.00	33,945,999.00	78.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	128,857,400.00	98,457,516.00	30,399,884.00	76.4
210101	Үндсэн цалин	94,078,700.00	78,410,774.00	15,667,926.00	83.3
210102	Нэмэгдэл	28,092,300.00	13,360,342.00	14,731,958.00	47.6
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,686,400.00	6,686,400.00	0.00	100.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	16,107,200.00	12,571,812.00	3,535,388.00	78.1
210201	Тэтгэврийн даатгал	10,952,900.00	8,602,503.56	2,350,396.44	78.5
210202	Тэтгэмжийн даатгал	1,288,600.00	1,012,060.55	276,539.45	78.5
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,030,900.00	809,645.61	221,254.39	78.5
210204	Ажилгүйдлийн даатгал	257,700.00	192,914.28	64,785.72	74.9
210205	Эрүүл мэндийн даатгал	2,577,100.00	1,954,688.00	622,412.00	75.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	7,385,200.00	7,385,200.00	0.00	100.0
210304	Байрны түрээс	7,385,200.00	7,385,200.00	0.00	100.0

Бөөнцагаан-Орог нуурын сав газрын захиргааны 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Код	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2104	Хангамж, бараа материалын зардал	4,815,100.00	4,805,613.00	9,487.00	99.8
210401	Бичиг хэрэг	444,200.00	444,200.00	0.00	100.0
210402	Тээвэр, шатахуун	2,449,400.00	2,440,000.00	9,400.00	99.6
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,133,200.00	1,133,113.00	87.00	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	788,300.00	788,300.00	0.00	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	581,200.00	580,000.00	1,200.00	99.8
210601	Багаж, техник, хэрэгсэл	581,200.00	580,000.00	1,200.00	99.8
2107	Томилолт, зочны зардал	1,099,200.00	1,099,200.00	0.00	100.0
210702	Дотоод албан томилолт	1,099,200.00	1,099,200.00	0.00	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	762,400.00	762,360.00	40.00	100.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	240,000.00	240,000.00	0.00	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	79,500.00	79,500.00	0.00	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	96,400.00	96,360.00	40.00	100.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	22,000.00	0.00	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	324,500.00	324,500.00	0.00	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	329,800.00	329,800.00	0.00	100.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	329,800.00	329,800.00	0.00	100.0
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	159,937,500.00	125,991,501.00	33,945,999.00	78.8
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	159,937,500.00	125,991,501.00	33,945,999.00	78.8
310001	Улсын төсвөөс санхүүжих	159,937,500.00	125,991,501.00	33,945,999.00	78.8
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	23	23		
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1		
610001	Төсвийн байгууллага	1	1		
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	11	11		
620001	Удирдах ажилтан	1	1		
620002	Гүйцэтгэх ажилтан	9	9		
620003	Үйлчлэх ажилтан	1	1		
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	11	11		
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	9	9		
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	2	2		

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		Өмнөх он	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	31,865,700.00	46,134,800.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	31,865,700.00	46,134,800.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	31,865,700.00	45,934,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	31,865,700.00	45,934,800.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		200,000.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг		200,000.00
213303	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг		200,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	31,865,700.00	45,934,800.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	33,200,000.00	46,134,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	33,200,000.00	46,134,800.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	33,200,000.00	46,134,800.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	0.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	0.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Бөөнцагаан-Орог нуурын сав газрын захиргаа нь “Сав газрын хэмжээнд усны нөөцийг хомсдол, бохирдлоос хамгаалах, боломжит нөөцийг зүй зохистой ашиглах орон нутгийн болон салбар дундын зохицуулалтыг хангах, Усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх” гэсэн эрхэм зорилгынхоо хүрээнд үйл ажиллагааныхаа зорилтыг тодорхойлжээ.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт *ороогүй* байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудит/аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Бөөнцагаан-Орог нуурын сав газрын захиргааны 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь Байгаль орчны яамны сайдын тушаалаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг нягтлан бодох бүртгэлд ашиглаж санхүүгийн тайлан бэлтгэхдээ мөрдөж ажиллаж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Бөөнцагаан-Орог нуурын сав газрын захиргааны 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт *ороогүй* байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 2,462.9 мянган төгрөгөөр буюу 2.8 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл		Эцсийн үлдэгдэл		Өөрчлөлт	
	Дүн	Эзлэх хувь	Дүн	Эзлэх хувь	Дүн	Хувь
А	1	2	3	4	5	6
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	28,284.2	31.9%	17,712.0	20.6%	(10,572.2)	-37.4%
Мөнгөн хөрөнгө	-	0.0%	-	0.0%	-	0.0%
Авлага	-	0.0%	5,000.0	5.8%	5,000.0	0.0%
Урьдчилгаа	8,000.0	9.0%	-	0.0%	(8,000.0)	-100.0%
Бараа материал	20,284.2	22.9%	12,712.0	14.7%	(7,572.2)	-37.3%
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	60,368.1	68.1%	68,477.5	79.4%	8,109.3	13.4%
Үндсэн хөрөнгө	144,579.4	163.1%	162,579.4	188.6%	18,000.0	12.4%
Хуримтлагдсан элэгдэл	(84,211.3)	-95.0%	(94,101.9)	-109.2%	(9,890.7)	11.7%
Нийт хөрөнгө	88,652.4	100.0%	86,189.5	100.0%	(2,462.9)	-2.8%
Өр төлбөр	85.1	0.1%	-	0.0%	(85.1)	-100.0%
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	88,567.3	99.9%	86,189.5	100.0%	(2,377.8)	-2.7%
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	88,652.4	100.0%	86,189.5	100.0%	(2,462.9)	-2.8%

Урьдчилгаа дансны үлдэгдэл 8000.0 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх онд төлсөн 8000.0 мянган төгрөгийн усны менежментийн төлөвлөгөөг хүлээн авч хөрөнгөд бүртгэсэнтэй холбоотой байна.

Авлага дансны үлдэгдэл 5000.0 мянган төгрөгөөр өссөн нь Бридж констракшн ХХК-тай байгуулсан гэрээний дагуу 5000.0 мянган төгрөгийн өртөг бүхий номын төлбөрийг шилжүүлсэн ч хүлээн аваагүй учир аудитын явцад санхүүгийн тайланд авлагаар тусгаж залруулга хийсэнтэй холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 12,712.0 мянган төгрөг болж 7,572.3 мянган төгрөгөөр буурсан нь сэлбэг хэрэгсэл дансны үлдэгдэл өмнөх оноос 1,216.8 мянган төгрөгөөр өссөн ч байгууллагын даргын 2022 оны А/24 дугаар тушаалын дагуу 5,240.0 мянган төгрөгийн бараа материал акталж данснаас хассан нь голлох нөлөөг үзүүлж байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 162,579.4 мянган төгрөг болж 18,000.0 мянган төгрөгөөр өссөн нь 18,000.0 мянган төгрөгийн усны менежментийн төлөвлөгөөг төсвийн хөрөнгөөр худалдан авч шинээр бүртгэсэнтэй холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 86,189.5 мянган төгрөг болж 2,377.8 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээр хуримтлагдсан 2,377.8 мянган төгрөгөөр буурсантай холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 240,818.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас бараа, ажил үйлчилгээний зардлыг 75,830,5 мянга бууруулж баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 3,345.1 мянган төгрөгөөр хасаж тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 1 арга хэмжээг санхүүжүүлэхээр 159,937.5 мянган төгрөгийг улсын төсвөөс баталсан байна

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 159,937.5 мянган төгрөгийн санхүүжилтийг бүрэн олгосон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 125,991.5 мянган төгрөг буюу 78.8 хувьтай байгаа нь орон тоо дутуу ажилласнаас шалтгаалан цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардлыг 33,946.0 мянган төгрөгөөр хэмнэгдсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	71404 Усны нөөц, нуур, гол мөрний	159,937.50	125,991.50	33,946.00	78.8%
2	80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	159,937.50	125,991.50	33,946.00	78.8%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоор 46,134.8 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, урсгал үйл ажиллагааны зардалд 45,934.8 мянган төгрөгийг зарцуулж 200.0 мянган төгрөгийг буцаан улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Бөөнцагаан-Орог нуурын сав газрын захиргааны 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Нарангэрэл гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер А.Цээням, Газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Бөөнцагаан-Орог нуурын сав газрын захиргааны 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлгэх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 201 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 196,922.5 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 2,953.8 мянган төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор 2022 оны байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 1,434.8 мянга, тээвэр шатахууны зардлыг 733.0 мянга, дотоод албан томилолтыг 1,807.6 мянга, бичиг хэргийн зардлыг 413.2 мянга нийт 4,388.6 мянган төгрөгийн хэмнэлт бий болгосон байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх,

нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар шилэн дансны нэгдсэн цахим хуудаст цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 165,075.8 мянган төгрөгийн 11 гүйлгээ, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 15,000.0 мянган төгрөгийн 2 гүйлгээ, өмч хөрөнгөтэй холбоотой 44,704.3 мянган төгрөгийн 6 шийдвэрийн мэдээллийг хуулийн хугацаанд бүрэн мэдээлсэн байна.

Харин “Дараа жилийн төсвийн төсөл”, “Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт”-1, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 34,861.7 мянган төгрөгийн 3 гүйлгээ, зарлагын 7,000.0 мянган төгрөгийн 1 гүйлгээг тус тус хугацаа хоцроож байршуулсан байна.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар 1,239.9 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоосныг 2022.03.14-ны өдөр бусад татварын хураамжийн орлогын дансанд бүрэн төвлөрүүлж, хэрэгжилтийн санхүүгийн тайлангийн аудитын FAS системд байршуулсан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	1	1239.9	1	1239.9	100.0
Нийт дүн	1	1239.9	1	1239.9	100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тайлант хугацаанд Бридж констракшн ХХК-тай байгуулсан гэрээний дагуу 5000.0 мянган төгрөгийн өртөг бүхий номын төлбөрийг шилжүүлсэн ч хөрөнгийг хүлээн аваагүй учир аудитын явцад санхүүгийн тайланд авлагаар тусгаж залруулга ба дараагийн аудитаар хөрөнгийг хүлээн авсан эсэхийг тодруулж үзэх шаардлагатай.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 6,500.0 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад залруулав. Үүнд:

1. Бридж констракшн ХХК-тай 50 ширхэг номыг нэг бүрийг 100000 төгрөгөөр хэвлүүлэх гэрээ хийж төлбөрийг 2022.12.22-ний өдөр шилжүүлсэн бөгөөд тус гэрээг байгуулсан огноо байхгүй, номыг хэзээ хүлээн авах огноо тодорхойгүй, уг номыг хүлээн аваагүй атлаа санхүүгийн тайланд авлагаар тусгагүй байна.
2. НИК компаниас худалдан авсан 1500.0 мянган төгрөгийн шатахууны тайланг гаргаагүй байхад нягтлан бодох бүртгэлд бүртгэсэн.

Аудитаар нийт 842.0, мянган төгрөгийн зөрчил² илэрснээс, 192.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 650.0 мянган төгрөгийн зөрчлийг давтан гаргуулахгүй байх 3 зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

5.1.1. Тайлант хугацаанд нийт 192.0 мянган төгрөгийн томилолтын зардлыг 4 албан хаагчид давхардуулан олгосон байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалтыг зөрчиж байна.

Шийдвэрлэсэн нь: Холбогдох буруутай албан тушаалтнаар төрийн сангийн бусад татвар хураамжийн орлогын дансанд төлүүлэхээр төлбөрийн актыг тогтоов.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Дотоод хяналт, хариуцлагатай холбоотой асуудал

Илрүүлэлт: Тус байгууллагын дарга нь албан хаагчдын 15 удаагийн томилолтын хугацааг сунгаагүйгээс тус бүр 1 өдрөөр илүү олгосон, 1 удаагийн томилолтын ирсэн буцсан хугацааг тавиагүй, 1 удаагийн томилолтын хугацааг зассан, 2 удаагийн томилолтод хугацаа зөрүүтэй байхад 650.0 мянган төгрөгийн томилолтын зардлыг олгосон байна.

Энэ нь Засгийн газрын 2019 оны "Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам"-ын 2.4 "Албан томилолтоор ажилласан хоногийн тоог албан томилолтоор ажиллуулах шийдвэрт тэмдэглэсэн хуанлийн хоногоор тооцож гаргана. Албан томилолтоор явсан, буцаж ирсэн өдрийг нэгтгэн нэг хоногт тооцно", 2.8 "Томилолтын хугацааг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хэтрүүлсэн тохиолдолд хэтрүүлсэн хугацааны байр, хоолны зардлыг олгохгүй" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Цаашид томилолтоор ажиллуулах шийдвэрт заасан хугацааг баримталж, илүү хоног ажилласан нөхцөлд томилолтын хугацааг сунгуулж Засгийн газрын 2019 оны "Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам"-ын 2.4, 2.8 дахь заалтуудыг мөрдөж, зөрчлийг давтан гаргахгүй байх.

2. Хууль журмын хэрэгжилттэй холбоотой асуудал

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Илрүүлэлт: Ажиллагсдын цалингаас хуулиар зөвшөөрөгдөөгүй суутгал хийж Хонгорын төлөө бидний сэтгэл ТББ руу 400.0 мянган төгрөгийг шилжүүлсэн байгаа нь Хөдөлмөрийн тухай хуулийн 119 дүгээр зүйлийн 119.1 дэх “Ажил олгогч ажилтны цалин хөлсийг бүрэн хэмжээгээр нь олгох бөгөөд дараах тохиолдолд суутгал хийж болно” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Байгууллагын ажиллагсдын цалин хөлс түүнтэй адилтгах орлогоос Хөдөлмөрийн тухай хуульд зааснаас бусад төрлийн суутгал хийдэг байдлыг таслан зогсоох.

3. Хууль журмын хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлант хугацаанд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст “Дараа жилийн төсвийн төсөл”, “Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт” 1-р сар, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 34,861.7 мянган төгрөгийн 3 гүйлгээ, зарлагын 7,000.0 мянган төгрөгийн 1 гүйлгээг 5-р сард тус тус хугацаа хоцроож мэдээлсэн байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3 “Дараа жилийн төсвийн төслийг жил бүрийн 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор”, “ 6.4.5 дахь “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр”, 6.4.7 “Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлж байх зөвлөмжийг нягтлан бодогчид, түүнд хяналт тавьж ажиллахыг төсвийн захирагчид хүргүүлэв.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 05 дугаар сарын 15 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй	
							Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайланд буруу бүртгэсэн										
Санхүүгийн тайланд бүртгээгүй	2	6,500.0	2	6,500.0			2	6,500.0		
Дүн	2	6,500.0	2	6,500.0			2	6,500.0		

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/					
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Байгууллагын дарга 2 удаагийн томиллолтод 4 мэргэжилтнийг өдөр давхардуулан өөр өөр газар ажиллуулахаар томилж зардлыг давхардуулан олгосон байна.	1	192.0	1	192.0				
Ажиллагсдын цалингаас хуулиар зөвшөөрөгдөөгүй суутгал хийж Хонгорын төлөө бидний сэтгэл ТББ руу 400.0 мянган төгрөгийг шилжүүлсэн байна.	1	0					1	0
Ажиллагсдын томиллолтоор ажиллуулах шийдвэрт заасан хоногийг зөрүүтэй байхад томилолтын	1	650.0					1	650.0

Бөөнцагаан-Орог нуурын сав газрын захиргааны 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Байгууллагын дарга 2 удаагийн томилолтод 4 мэргэжилтнийг өдөр давхардуулан өөр өөр газар ажиллуулахаар томилж зардлыг давхардуулан олгосон байна.	1	192.0	1	192.0				
зардлыг олгосон байгаа нь Засгийн газрын 2019 оны "Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам"-ын 2.4, 2.8 дахь заалтыг зөрчсөн.								
Нийт дүн	3	842.0	1	192.0			2	650.0

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Тайлант хугацаанд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст "Дараа жилийн төсвийн төсөл", "Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт" 1-р сар, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 34,861.7 мянган төгрөгийн 3 гүйлгээ, зарлагын 7,000.0 мянган төгрөгийн 1 гүйлгээг хугацаа хоцроож мэдээлсэн байна.	1	-					1	-
Дүн	1	-				-	1	-